

БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН ШУУДАН, ЦАХИМ ХУДАЛДААНЫ БОДЛОГО ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Б.ТУНГАЛАГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
	1	2	3	4	5		6	7
ЗОРИЛТ 1. “САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ, БОДЛОГЫН УДИРДАМЖААР ХАНГАХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД								
1	Арга хэмжээ 1.1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор 109 хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг салбар, орон нутагт сурталчлан таниулна.	Арга хэмжээний тоо	-	4	Төрийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуулиудад орсон нэмэлт, өөрчлөлтийг салбар бүрд танилцуулж, төрийн албан хаагч нарт мэдээлэл өгөх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Шилэн төр, төрийн хурдан үйлчилгээ” уулзалт, зөвлөгөөнийг Монголын хүүхдийн ордны их танхимд 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Боловсролын байгууллагын 500 гаруй албан хаагч, 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Эрүүл мэндийн салбарын 400 орчим албан хаагч, 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр хууль сахиулах байгууллагын 350 орчим албан хаагч, Төрийн албаны 400 орчин албан хаагчид нарыг хамруулан тус тус зохион байгуулсан.		01.02-06.28	100

2.	Арга хэмжээ 1.2. Монгол Улсаас гадаад улсад суугаа элчин сайдын яамдын цахим шилжилтийн бэлэн байдлын үнэлгээ хийх журмын төслийг боловсруулах	Журмын төслийн тоо	-	1	Монгол Улсаас гадаад улсад суугаа 33 дипломат төлөөлөгчийн газраас “Хилийн чанад дахь Монгол Улсын иргэдэд төрийн үйлчилгээг хүргэхэд тулгамдаж буй асуудлууд”-ын талаар судалгаа авч, журмын төслийг боловсруулсан.	01.02-06.28	100
3.	Арга хэмжээ 1.3. Шуудангийн нэгдсэн кодыг хэрэглэх, нэвтрүүлэх журмын төслийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	-	1	Шуудангийн нэгдсэн кодыг хэрэглэх, нэвтрүүлэх журмын төслийн эхний хувилбарыг боловсруулсан.	06.03-12.06	50
4.	Арга хэмжээ 1.4. Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журамд нэмэлт, өөрчлөлт оруулж, эрх бүхий байгууллагатай хамтран батлуулна.	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	-	1	Журмын төсөлд оруулах саналуудыг судалж, эхний байдлаар боловсруулсан. Тус яамнаас 2024 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр Бю Скай зочид буудалд зохион байгуулсан “Шийдэлтэй уулзалт: Шуудангийн салбарын шинэчлэл” уулзалтын үеэр Гаалийн байгууллагын төлөөлөлтэй уулзаж, уг журмын талаар санал солилцож, гаалийн мэдүүлгийн системийг хэрхэн хур системтэй холбох, энэ талаарх зохицуулалтыг энэ журмын төсөлд тусгах шаардлагатай гэж үзээд хойшлуулсан.	06.03-12.06	50
ЗОРИЛТ 2. “ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
5.	Арга хэмжээ 2.1. Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын дэмжлэгээр хийгдэх “Нээлттэй өгөгдөл ашиглах хөтөлбөр боловсруулах” хүрээнд хакатон тэмцээн зохион байгуулна.	Тэмцээний тоо	-	1	Нээлттэй өгөгдөл дээр тулгуурлан эрүүл мэндийн салбарын асуудлыг шийдэх туршилтын загвар /прототайп/ бүтээх хакатон зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, удирдамж боловсруулж, олон нийтэд нээлттэйгээр 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс 08 дугаар сарын 26-ны өдөр хүртэл зарласан. Тус хакатон тэмцээнд оролцох хүсэлт ирүүлсэн 13 байгууллагуудын материалыг хянаж 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр эхний шатны шалгаруулалтыг хийж тэнцсэн 8 байгууллагад мэдэгдлийг хүргүүлсэн. Төгсгөлийн шатны шалгаруулалтыг 2024 оны 09 дүгээр сарын 02-ны өдрөөс 09 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулж, нийт 8 баг эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх, төрийн үйлчилгээг сайжруулахад хувь нэмрээ оруулах зорилгоор нээлттэй өгөгдлийг ашиглан, бизнесийн загваруудыг боловсруулж танилцуулсан. Тус хакатон тэмцээний тэргүүн байранд “Rookie systems”, дэд байранд “Data med” багууд шалгарсан.	01.02-12.06	100

6.	Арга хэмжээ 2.2. Их өгөгдөл, хиймэл оюун ухаан, зүйлсийн интернэт, үүлэн технологи, машин сургалт зэрэг дэвшилтэт технологийн хэрэглээнээс үүсэх эмзэг байдал, эрсдэлийн судалгаа хийнэ.	Судалгааны тоо	1	-	Гүн сургалтын аргуудад суурилсан Зүйлсийн интернетийн (IoT) экосистем дэх кибер халдлагуудыг илрүүлэх болон хариу арга хэмжээ авах судалгааг хийсэн. Мөн Кибер гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын судалгааг хийсэн.	01.02-06.03	100
ЗОРИЛТ 3. "КИБЕР ХАЛДЛАГА, ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ НИЙТИЙН ТӨВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БЭХЖҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
7.	Арга хэмжээ 3.1. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийг олон улсын байгууллагад гишүүнээр элсэх боломжийг судалж, санал боловсруулна.	Саналын тоо	-	1	Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвтэй хамтран APCERT (Asia Pacific Computer Emergency Response Team) нь Ази Номхон далайн бүс нутгийн мэдээллийн аюулгүй байдлын хариу үзүүлэх олон улсын хамтын ажиллагааны байгууллага, FIRST (Forum of Incident Response and Security Teams) буюу дэлхийн хэмжээнд кибер халдлагын хариу арга хэмжээ, аюулгүй байдлын хамтын ажиллагааг дэмждэг олон улсын байгууллагуудад гишүүнээр элсэх хүсэлтийг холбогдох шаардлагын дагуу хүргүүлэн 2024 оны 6-р сард гишүүнчлэлээр бүртгүүлсэн. Мөн Монгол Улсад үндэсний хэмжээний кибер аюулгүй байдлыг ханган ажиллаж буй National CERT – Төрийн байгууллагын кибер аюулгүй байдлыг хариуцах, Public CSIRT/CC - Иргэн, хуулийн этгээдийн кибер аюулгүй байдлыг хангах төвүүдийг 2024 онд олон улсын болон бүс нутгийн байгууллагуудад гишүүнээр элсүүлэхэд дэмжлэг үзүүлэх саналыг Америкийн Нэгдсэн Улс, Герман Улс, Их Британи, Умардын Ирландын Нэгдсэн Хаант Улс зэрэг улсуудад тавьсан.	01.02-12.06	100
ЗОРИЛТ 4. "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
8.	Арга хэмжээ 4.1. ТЖАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журамд заасан хугацаанд боловсруулж батлуулах, тайлагнах	Батлуулсан төлөвлөгөөний тоо, тайлангийн тоо	0	3	- Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хуулийн хугацаанд боловсруулж, нэгжийн удирдлагаар баталгаажуулсан. - Төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийг батлагдсан загварын дагуу 2024 оны 06 дугаар сарын 10 өдөр тайлагнасан. - Төлөвлөгөөний сүүлийн хагас жилийн биелэлтийг батлагдсан загварын дагуу 2024 оны 12 дугаар сарын 06 өдөр тайлагнасан.	01.02-12.06	100
9.	Арга хэмжээ 4.2. Чиг үүргийн дагуу төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн	Хүргүүлсэн биелэлтийн тоо		1	Газрын хэмжээнд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг	01.02-12.06	100

	хэрэгжилт болон шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх		0		өөрийн чиг үүргийн хүрээнд тухай бүр боловсруулан тайлагнасан.		
10.	Арга хэмжээ 4.3. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, холбогдох журамд заасны дагуу цохогдсон албан бичиг, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэх	Шийдвэрлэсэн албан бичгийн тоо	0	1	Нийт 113 албан бичиг хүлээн авч шийдвэрлэж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.	01.02-12.06	100
11	Арга хэмжээ 4.4. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх	ХАСХОМ маягтын тоо, Ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийн тоо	0	1	1. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг зааврын дагуу гарган 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталгаажуулсан. 2. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн Б/75 дугаар тушаалаар чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбогдуулан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг зааврын дагуу гарган 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр баталгаажуулсан.	01.02-06.28	100
12.	Арга хэмжээ 5.5. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох журамд заасны дагуу хөтлөх нэрийн жагсаалтад заасан баримт бичгийг архивлах	Архивласан баримтын тоо	0	1	1.Бүгд Найрамдах Солонгос Улсын КТ корпорацтай хамтран Үндэсний цахим шилжилтийн стратеги төлөвлөгөө боловсруулах санал, зөвлөмжийн тайлан 2. Бүгд Найрамдах Эстони Улсын Цахим засаглалын академитай хамтран Үндэсний танилт нэвтрэлтийн систем, тогтолцооны өнөөгийн нөхцөл байдлыг судлах, системийн цаашдын сайжруулалт, аюулгүй байдлын талаарх санал, зөвлөмжийн тайланг архивт тус тус хүлээлгэн өгсөн.	01.02-06.28	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар 1. Цаг үеийн болон бусад асуудлаар удирдлагад бодлогын дэмжлэг үзүүлэн ажиллах хүрээнд	Боловсруулсан төслийн тоо	0	1	Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон удирдлагууд дор дурдсан улс, оронд айлчлах үеэр ярих ярианы сэдвийг бэлтгэсэн:	01.02-12.06	100

					1. 2024 оны 1 дүгээр сарын 25-наас 2 дугаар сарын 04-ний өдрүүдэд Америкийн Нэгдсэн Улсад хийсэн айлчлалын хүрээнд 4 уулзалтын ярианы сэдэв; 2. Арабын Нэгдсэн Эмират Улсын Дубай хотноо зохион байгуулагдсан “Дэлхийн засгийн газруудын дээд түвшний уулзалт”-д оролцох хүрээнд 2 уулзалтын ярианы сэдэв болон хэлэлцүүлэгтэй холбоотой мэдээлэл; 3. Монгол Улсад суухад суугаа Америкийн Нэгдсэн Улс, Герман Улс, Их Британи, Умардын Ирландын Нэгдсэн Улсуудын элчин сайдуудтай уулзах уулзалтын ярианы сэдэв; 4. Тайландын Бангкок хотноо 2024 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулагдах “Expanding Digital: Innovations for SDG Fulfillment” арга хэмжээний үеэр Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралын хэлэх үг; 5. ЦХХХ-ны Сайд Н.Учралын Бүгд Найрамдах Казакстан Улсын Цахим хөгжил, инновац, сансар судлалын нэгдүгээр дэд сайд Түлейшин Канушыг хүлээн авч уулзах үеэр ярих ярианы сэдэв; 6. ЦХХХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэгийн АНУ-д айлчилж “Global Digital Summit 2024” арга хэмжээнд оролцох үеэр танилцуулах танилцуулга, хэлэлцүүлэгтэй холбоотой мэдээлэл, Дэлхийн банкны төлөөлөлтэй уулзах уулзалтын ярианы сэдэв; 7. Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг Япон Улсад Ази, Номхон Далайн цахилгаан холбооны байгууллагаас зохион байгуулах дээд түвшний албан хаагчдад зориулсан бодлого боловсруулах семинарт танилцуулах Монгол улсын цахим шилжилтийн өнөөгийн байдлын талаарх танилцуулга, хэлэлцүүлгийн үеэр ирэх асуултын хари, хүлээн авалтын үеэр хэлэх үг; 8. Казакстан Улсын Астана хотноо зохион байгуулагдсан “CAREC Digital Trade Forum”-ын үеэр тус газрын дарга Х.Сүрэнхоролын танилцуулах “Монгол Улсын цахим худалдааны өнөөгийн байдал” танилцуулга;		
--	--	--	--	--	---	--	--

					9. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх Ч.Золбаяр япон улсын "GMO" интернэт групп компанийн төлөөлөлтэй уулзах уулзалтын үеэр ярилцах ярианы сэдвийг тус тус бэлтгэсэн. 10. Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг Япон Улсад Ази, Номхон Далайн цахилгаан холбооны байгууллагаас зохион байгуулах дээд түвшний албан хаагчдад зориулсан бодлого боловсруулах семинарт танилцуулах Монгол улсын цахим шилжилтийн өнөөгийн байдлын талаарх танилцуулга, хэлэлцүүлгийн үеэр ирэх асуултын хари, хүлээн авалтын үеэр хэлэх үг; 11. Бүгд Найрамдах Латви Улс, Швейцарын Холбооны Улс, Бүгд Найрамдах Финланд Улс болон Гадаад харилцааны яам хоорондын Улс төрийн ээлжит зөвлөлдөх уулзалтын үеэр ярих ярианы сэдвийн санал; 12. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн 2024 оны 04 дүгээр сарын 21-24-ний өдрүүдэд Тайландын Хаант Улсад хийсэн албан ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд санал; 13. Бүгд найрамдах Узбекистан Улсад 2024 оны 06 дугаар сард хийх дээд түвшний айлчлалын үеэр Монгол, Узбекистаны хамтарсан төсөл хөтөлбөрт тусгах санал; 14. Америкийн Нэгдсэн Улсын Төрийн нарийн бичгийн даргын орлогч Курт Кэмпбэлл Монгол Улсад айлчлах үеэр ярих асуудлын хүрээнд кибер аюулгүй байдлын чиглэлээр мэдээлэл солилцох механизм бий болгох, хүний нөөцийг чадавхжуулах, хиймэл оюун ухаан болон цахим төлбөр тооцооны чиглэлээр хамтран ажиллах санал; 15. Сайд Ц.Баатархүү Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны Монгол дахь суурин төлөөлөгч Ханнес Такачиг 2024 оны 10 дугаар сарын 21-ны өдөр хүлээн авч уулзсан уулзалтын ярианы сэдэв; 16. Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү Мобиком корпорацийн зөвлөх Кобаяши Хироюкиг		
--	--	--	--	--	---	--	--

					2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр хүлээн авч уулзсан уулзалтын ярианы сэдэв;		
2.	Үүрэг даалгавар 2. Гадаад хамтын ажиллагааны болон харилцан ойлголцлын санамж бичигт санал өгөх	Саналын тоо	0	1	1. Япон улсын компьютерын яаралтай байдлын бүгдийн зохицуулах төвтэй Монгол улсын Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв кибер аюулгүй байдлын хамтын ажиллагааны тухай харилцан ойлголцлын санамж бичгийг хянаж санал өгсөн. 2. Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Америкийн Нэгдсэн Улсын Oracle корпорац хоорондын инновац, дижиталчлал, өгөгдлийн менежментийн чиглэлээр хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг хянаж санал өгсөн.	01.09-06.28	100
3.	Үүрэг даалгавар 3. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын А/170 дугаар тушаалаар байгуулсан "Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн хүсэлтийг магадлан шалгаж, зөвлөмж танилцуулах" үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах	Зөвлөмжийн тоо	0	1	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын А/170 дугаар тушаалаар байгуулсан "Мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн хүсэлтийг магадлан шалгаж, зөвлөмж танилцуулах" үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж, Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх зөвшөөрөл эзэмших хүсэлт ирүүлсэн хуулийн этгээдийн баримт бичгийг магадлан шалгаж, ажлын хэсгийн гишүүдтэй хамтран зөвлөмж боловсруулан ажилласан.	01.09-12.06	100
4.	Үүрэг даалгавар 4. Гадаад хамтын ажиллагаанд санал өгөх	Саналын тоо	0	1	1 Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Ерөнхийлөгч Франк-Вальтер Штайнмайэрын Монгол Улсад хийсэн Төрийн айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл болон Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс хоорондын Стратегийн түншлэлийн тухай хамтарсан тунхаглалын төсөлд санал; 2. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Швейцарын Холбооны Улсын Давос хотноо болсон Дэлхийн эдийн засгийн 54 дүгээр чуулга уулзалтад оролцсон мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөл болон Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөлд санал; 3. Монгол улсын Засгийн газраас хилийн чанад дахь Монгол иргэдийг эх оронд нь буцаан	01.09-12.06	100

					авчрах санаачилга болон уг арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах хүрээнд өмнө нь хэрэгжүүлсэн “Зөгийн үүр” хөтөлбөрийн биелэлт болон 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээнд санал; 4. Монгол Улс, Бүгд найрамдах Солонгос улсын Засгийн газар хоорондын Хамтарсан хорооны VIII хуралдааны удирдамж, протоколын төсөл болон хуралдааны яриа хэлэлцээний сэдэвт санал; 5. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Узбекистаны Засгийн газар хоорондын комиссын анхдугаар хуралдаанд санал; 6. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн сайд Дэвид Камероны 2024 оны 04 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан ёсны айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд санал; 7. Америкийн Нэгдсэн Улсын Төрийн нарийн бичгийн даргын орлогч Курт Кэмпбэлл Монгол Улсад айлчлах үеэр ярих асуудлын хүрээнд кибер аюулгүй байдлын чиглэлээр мэдээлэл солилцох механизм бий болгох, хүний нөөцийг чадавхжуулах, хиймэл оюун ухаан болон цахим төлбөр тооцооны чиглэлээр хамтран ажиллах саналыг тус тус боловсруулсан.		
5.	Үүрэг даалгавар 5. Кибер аюулгүй байдлын зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 03 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллах	Зөвлөмжийн тоо	0	1	Хүний хувийн мэдээлэл хакеруудын хар зах дээр түгээгдэж буйтай холбогдуулан халдлага зөрчилд дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийн хуралд тухай бүр оролцож санал солилцон ажиллаж байна.	03.22-12.06	100
6.	Үүрэг даалгавар 6. Боловсрол, шинжлэх ухааны Сайдын 2024 оны 05 дугаар сарын 01-ний А/204 дүгээр тушаалаар байгуулагдсан Азийн Шинжлэх Ухааны Паркуудын холбоо (ASPA)-ны 27 дугаар чуулга уулзалтыг	Арга хэмжээний тоо	0	1	Боловсрол, шинжлэх ухааны Сайдын 2024 оны 05 дугаар сарын 01-ний А/204 дүгээр тушаалаар байгуулагдсан Азийн Шинжлэх Ухааны Паркуудын холбоо (ASPA)-ны 27 дугаар чуулга уулзалтыг нийт 400 гаруй, үүнээс Азийн орнуудаас 60 гаруй төлөөлөгчийг оролцуулж 2024 оны 8 дугаар сарын	05.01-08.21	100

	2024 оны 8 дугаар сарын 19-21-ний өдрүүдэд анх удаа Монгол Улсад зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллах				19-21-ний өдрүүдэд анх удаа Монгол Улсад зохион байгуулсан.		
7.	Үүрэг даалгавар 7 Шуудангийн стандартад үзлэг хийх	Стандартын тоо	0	4	Харилцаа холбооны зохицуулах хорооны 2024 оны А/272 дугаар тушаалаар байгуулагдсан "Шуудан холбооны стандартуудын үзлэгийг зохион байгуулах" ажлын хэсгийн хүрээнд дараах стандартуудад үзлэг хийж, цаашид боловсруулах шаардлагатай стандартын саналыг боловсруулан ажлын хэсэгт хүргүүлсэн. Үүнд: 1.MNS 5972:2009, Шуудангийн маркийн хадгалалт, хамгаалалтад тавих шаардлага; 2.MNS 5539:2019, Шуудангийн аюулгүй байдал; 3. MNS 5978:2024, Шуудангийн хайрцаг; 4.MNS 6775:2024, Хаягийн бичвэрт тавих шаардлага.	10.09-11.15	100
8.	Үүрэг даалгавар 8 Ажлын даалгавар боловсруулах	Ажлын даалгаварын тоо	0	1	Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/38 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2024 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө"-ний дагуу "Цахим эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, сайн туршлагын судалгаа хийх" ажлын даалгаврыг боловсруулан 2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан.	10.10	100
9.	Үүрэг даалгавар 9. Монгол Улсын Эдийн засгийн форум зохион байгуулах	Арга хэмжээний тоо	0	1	"Go Mongolia" уриан дор зохион байгуулагдсан Монголын Эдийн Засгийн Чуулган зохион байгуулахад Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтран чуулганы салбар хуралдаан болох "Дижитал засаглал ба дижитал эдийн засаг-гаргасан ахиц" салбар хурлыг зохион байгуулах ажлын хэсэгт ажилласан. Мөн Эдийн засгийн форум сэтгүүлд ТНБД Б.Батцэцэгийн Дижитал эдийн засгийн чиглэлээр ярилцлага өгөх сэдвийг бэлтгэсэн	07.08-09	100

10.	Үүрэг даалгавар 10. Олон улсын заал, буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх төслийн санал боловсруулах	Боловсруулсан төслийн саналын тоо	0	2	Сангийн яамнаас ирүүлсэн саналын дагуу Япон улсын Жайка хамтын ажиллагааны байгууллагад Стартапын экосистемийг бий болгох төсөл; Солонгос улсын Койка хамтын ажиллагааны байгууллагад Шуудангийн логистик төв байгуулах төслийн саналыг тус тус хүргүүлсэн.	07.08 08.25	100
11.	Үүрэг даалгавар 11. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/35 дугаар тушаалаар байгуулагдсан “Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн хүсэлтийг магадлан шалгаж, зөвлөмж танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт	Зөвлөмжийн тоо	0	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/35 дугаар тушаалаар байгуулагдсан “Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдийн хүсэлтийг магадлан шалгаж, зөвлөмж танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллаж Гэрэгэ системс ХХК-аас ирүүлсэн хүсэлтийг Цахим гарын үсгийн тухай хууль, Тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийг сонгон шалгаруулах журамд заасны дагуу магадлан шалгаж, дүгнэлт боловсруулсан.	10.10	100

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан ажлын чиглэлээр байгууллагаас болон бусад газраас зохион байгуулсан хурал, зөвлөгөөнд оролцох	Тухай бүр холбогдох хурал, зөвлөгөөнд хамрагдсан байна.	0	1	1 Хүний эрхийн комиссоос 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан “Цахим эринд хүний эрхэд суурилсан хөгжлийг дэмжих нь” симпозиумд оролцсон. 2.Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/, Япон Улсын Deloitte зөвлөх үйлчилгээний компанийн төлөөлөл Монголд Улсад хүрэлцэн ирж Монгол Улсад мэдээллийн технологид тулгуурласан цахим үйлдвэрлэл болон харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын программ хангамж үйлдвэрлэгч стартап компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг гадны зах зээлд сурталчлах төслийг 2023-2025 онд хэрэгжүүлэх явцын	01.02-12.06	100

					талаар болон Нээлттэй өгөгдөл ашиглах хөтөлбөр боловсруулах төслийн талаар төр хувийн хэвшлийн төлөөллүүдтэй уулзалт зөвлөгөөнийг хийсэн.		
2.	Арга хэмжээ 2. Хариуцсан ажлын чиглэлээр байгууллагаас болон бусад газраас зохион байгуулсан сургалт, семинарт оролцох	Тухай бүр холбогдох сургалт, семинарт хамрагдсан байна.	0	1	1.Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр зохион байгуулдаг 7:4:10 онлайн сургалтад тухай бүр хамрагдсан. 2.Нийтийн албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг хууль тогтоомж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалт, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргахтай холбоотой мэдлэг олгох сургалтад хамрагдсан. 3. ШУТИС-ын Мэдээлэл холбооны технологийн их сургуульд суралцаж Утасгүй холбооны магистрын зэрэг хамгаалсан. 4. Мэргэшсэн инженерийн сургалтад хамрагдаж мэргэшсэн инженерийн зэрэг горилох шалгалт өгсөн. 5. БНХАУ-ын Худалдааны Яамнаас зохион байгуулсан "Дэлхийн тогтвортой хөгжил - Хил дамнасан цахим худалдаагаар ядуурлыг бууруулах" сургалт нь 2024 оны 9 сарын 17-ны өдрөөс 2024 оны 10 сарын 03-ны өдрүүдийн хооронд БНХАУ-ын Ханжой хотын Жейжанг мужид зохион байгуулагдсан сургалтад суусан.	01.02-12.06	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Шуудан, цахим худалдааны бодлого хариуцсан ахлах
мэргэжилтэн
(Албан тушаал)

Б.Тунгалаг / Б. Тунгалаг /
(Нэр, гарын үсэг)

2024 12 06
(Огноо)